



2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.07.09

Орхон аймаг

Нэг. Шалгалтын үндэслэл, зорилго

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/558 тоот зөвлөмжийн дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2024 оны хётлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд дотоод аудит, үнэлгээ хийж, зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

Хоёр. Шалгалтын явуулсан хугацаа, бүрэлдэхүүн

Шалгалтыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн хооронд хугацаанд Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга Г.Галбадрах, улсын байцаагч Д.Дуламсүрэн нар аудитыг хийж гүйцэтгэн ажилласан.

Гурав. Шалгалтын дүнгийн талаар

3.1 Шилэн дансны хётлөлт, мэдээлэл байршуулсан байдал:

3.1.1 Шилэн дансны хётлөлт:

Үйл ажиллагааны мэдээлэл оруулахдаа:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ цэсэд оруулах 4 болон 5 сарын мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж байршуулсан.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ цэсэд оруулах 1-6 саруудад оруулсан мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж байршуулсан.
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн цэсэд байршуулах 5 шийдвэрийг 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж байршуулсан.


Сангийн мэдээллийн оруулахдаа:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын болон орлогын мөнгөн гүйлгээ цэсэд оруулах 1-6 саруудын мэдээллийг гүйлгээ хийсэн дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж байршуулсан.



3.1.2 Мэдээлэл байршуулсан байдал:

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 78 ба мэдээлээгүй 81 байна.



- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 85 ба мэдээлээгүй 86 байна.



3.2 Аудитаар илэрсэн шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилттэй холбоотой зөрчлийг бүрэн арилгасан байх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Орхон аймгийн дахь Төрийн аудитын газрын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хугацааны нэгдсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд явцын шалгalt хийж шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага ёгсөн.Үүнд:

Зөрчил: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ талбарт 361,2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.



2024 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулахтай холбоотой 5 мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж ажилласан байна.

Дөрөв. Дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу төсвийн байгууллага үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс эхний хагас жилийн байдлаар тухай бүр, сар, улирал, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 163 мэдээллийг байршуулсан, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж ажилласан.

Тав. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзах оруулах мэдээлэл байхгүй уед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дарааллын дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвших, хэмнэлт хэтрэлтийн тайлбарыг бүрэн гүйцэт бичиж оруулах, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулах, хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг нягтлан бодогчид 7 хоногийн дотор ёгч хэвших цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ТАСГИЙН ДАРГА

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ТАСГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

ТАНИЛЦСАН:

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ДАРГА

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЯГТЛАН БОДОГЧ

САНГИЙН НЯГТЛАН БОДОГЧ



Г.ГАЛБАДРАХ

Д.ДУЛАМСҮРЭН

Ү.МЯГМАРСҮРЭН

Д.ИДЭРЖАВХЛАН

Т.ДАВААЖАРГАЛ

Б.РАЯА